



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/41

Ховд

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
байгуулах тухай


Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18.2.4, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх хэсэг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2021 ошны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/190, А/280 дугаар тушаалыг үндэслэн аймгийн “Хүүхдийн эрхийн хууль зүй хорооны бүрэлдэхүүн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай

2. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа болон гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдүүдэд хяналт тавьж, гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны дарга (Д.Дэлгэрсайхан)-д даалгасугай

3. Захирамж гарсантай холбоотойгоор Ховд аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/50 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 19-ний өдрийн
А/41 дүгээр захирамжийн хавсралт

АЙМГИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Хорооны дарга: - Аймгийн Нийгмийн бодлогын асуудал хариуцсан
Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн
газрын дарга
- Гишүүд:
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн
бичгийн дарга
 - Аймгийн Засаг даргын Тамгын газрын газрын Хууль
эрх зүйн хэлтсийн дарга
 - Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
 - Аймгийн Прокурорын газрын дарга
 - Аймгийн Цагдаагийн газрын дарга
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
 - Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
 - Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга
 - Аймгийн эрүүл мэндийн газрын дарга
 - Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
газрын дарга
 - Аймгийн Хүний эрхийн үндэсний комиссын ажилтан
 - Аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга
/Зөвшилцсөнөөр/
 - Аймгийн Хүүхдийн элч /Зөвшилцсөнөөр/
 - Хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн
бус байгууллага

-оОо-